

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар: 15

Улаанбаатар хот

Нөхөн төлбөр олгох тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 21 дүгээр зүйлийн 21.2.3, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 107/53 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.1.1, 4.1.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2024 оны эхний хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн Үндэсний статистикийн хорооноос гаргасан малын хорогдлын албан ёсны мэдээллийг үндэслэн “Малын индексжүүлсэн даатгалын гэрээ” болон “Малын индексжүүлсэн даатгалын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ”-нд заасны дагуу 22,034 даатгуулагчдад учирсан хохирол болох нийт 16,817,662,257.18 (арван зургаан тэрбум найман зуун арван долоон сая зургаан зуун жаран хоёр мянга хоёр зуун тавин долоон төгрөг арван найман мөнгө) төгрөгийн нөхөн төлбөрөөс 2,249,450,945.15 (хоёр тэрбум хоёр зуун дөчин есөн сая дөрвөн зуун тавин мянга есөн зуун дөчин таван төгрөг арван таван мөнгө) төгрөгийн нөхөн төлбөрийг Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас, 2,780,621,346.87 (хоёр тэрбум долоон зуун наян сая зургаан зуун хорин нэгэн мянга гурван зуун дөчин зургаан төгрөг наян долоон мөнгө) төгрөгийн нөхөн төлбөрийг Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас, 850,677,165.13 (найман зуун тавин сая зургаан зуун далан долоон мянга нэг зуун жаран таван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос хуримтлуулсан хөрөнгөөс, олон улсын давхар даатгагчийн хариуцах 8,646,644,559.45 (найман тэрбум зургаан зуун дөчин зургаан сая зургаан зуун дөчин дөрвөн мянга таван зуун тавин есөн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийг компанийн бусад нөөц сангийн хөрөнгөөс тус тус гаргаж даатгагчдад олгосугай.

2. Дээд болон Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан, үндсэн үйл ажиллагааны орлогоос хуримтлуулсан хөрөнгө, компанийн бусад нөөц сангийн хөрөнгөөс нөхөн төлбөр авах даатгагчдын нэрс, давхар даатгагчаас даатгагчдад олгох нөхөн төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Дээд түвшний эрсдэлээс хамгаалах олон улсын давхар даатгалын гэрээний дагуу 2,191,514,964.84 (хоёр тэрбум нэг зуун ерэн нэгэн сая таван зуун арван дөрвөн мянга есөн зуун жаран дөрвөн төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийг, Дунд түвшний эрсдэлээс хамгаалах олон улсын давхар даатгалын гэрээний дагуу 6,455,129,594.60 (зургаан тэрбум дөрвөн зуун тавин таван сая нэг зуун хорин есөн мянга таван зуун ерэн дөрвөн төгрөг жаран мөнгө) төгрөгийг олон улсын давхар даатгагч “СКОР” компаниас тус тус нэхэмжлэн авахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

4. 22,034 даатгуулагчийн нэрсийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах, Дээд болон Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан, үндсэн үйл ажиллагааны орлогоос хуримтлуулсан хөрөнгө, компанийн бусад нөөц сангийн хөрөнгөөс олгох нөхөн төлбөрийг Хамтын эрсдэлийн сангаас олгох 2,290,268,240.58 (хоёр тэрбум хоёр зуун ерэн сая хоёр зуун жаран найман мянга хоёр зуун дөчин төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн нөхөн төлбөртэй нэгтгэн даатгагчдад хуваарилах, нөхөн төлбөр олгох ажлыг хууль, журамд заасны дагуу зохион байгуулж, энэ талаарх тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д даалгасугай.

5. Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр өндөр гарсантай холбогдуулан энэ даатгалын үр нөлөө, ач холбогдлыг малчдад сурталчлан таниулах чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ